# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ТТЗ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2025/020/НА-СТА-ТТЗ**


Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Даваанярм

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 1/325

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Х.ТАЙВАНБАЯР ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мөрөн сумын Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэн үндсэн хөрөнгөнд бүртгэж үндсэн хөрөнгийг 3,812.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 3 нэр төрлийн орлогын төлөвлөгөө нийт 202.3 сая төгрөгөөр тасарсан, хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан 3 иргэнтэй холбоотой 43.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулаагүй зэрэг зөрчил илэрсэн.

### Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 7 зорилтын 145 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 97.7 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох

6727022157

бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 3,532,134.4 | 6,162,335.0 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 2,643,333.4 | 5,326,686.1 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 455,839.5 | 313,674.5 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 7а, 7б | 0.0 | 580.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 432,961.5 | 521,394.5 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 33,155,086.5 | 37,033,949.1 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 11а, 11б | 557,634.0 | 624,285.7 |
| 37300 | Урт хугацаат зээл | | 557,634.0 | 624,285.7 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 32,597,452.5 | 36,409,663.4 |
| 39200 | Биет хөрөнгө | | 21,881,969.6 | 25,678,060.5 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 10,715,482.9 | 10,731,602.9 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 36,687,221.0 | 43,196,284.2 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 172,139.8 | 228,031.9 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 172,139.8 | 228,031.9 |
| 41300 | Өглөг | 17а, 17б | 172,139.8 | 228,031.9 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 36,515,081.2 | 42,968,252.2 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 36,515,081.2 | 42,968,252.2 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 13,218,605.8 | 14,032,796.8 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 19,380.3 | 19,380.3 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 22,660,302.6 | 28,299,282.7 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 616,792.5 | 616,792.5 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 36,687,221.0 | 43,196,284.2 |

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 18,319,232.8 | 31,754,909.8 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 13,092,981.3 | 22,043,617.3 |
| 110 | Орлогын албан татвар | 10,943,034.1 | 19,393,433.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 11,655,534.1 | 19,393,433.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -712,500.0 | 0.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 635,154.0 | 818,089.3 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 1,514,793.2 | 1,832,095.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,201,837.1 | 5,459,307.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,201,837.1 | 5,448,095.1 |
| 121 | Хөрөнгийн орлого | 0.0 | 3,900.0 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 7,312.5 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,024,414.5 | 4,251,984.9 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 17,521,861.4 | 26,028,292.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 17,521,861.4 | 26,028,292.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 13,424,678.4 | 15,944,922.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,021,078.5 | 1,767,533.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 128,082.0 | 218,406.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 140,406.5 | 4,304,014.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 918,856.1 | 1,088,496.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 46,200.0 | 517,775.7 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 27,806.2 | 30,915.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,214,469.9 | 1,461,770.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,927,779.3 | 6,556,011.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 212 | ТАТААС | 1,638,201.2 | 3,128,000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,458,981.8 | 6,955,369.5 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 797,371.4 | 5,726,617.8 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 3,779.6 | 0.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 640,486.3 | 187,253.7 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 160,664.6 | 5,539,364.2 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 18,248,643.4 | 27,776,704.3 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 13,092,981.3 | 22,043,617.3 |
| 110 | Орлогын албан татвар | 10,943,034.1 | 19,393,433.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 11,655,534.1 | 19,393,433.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -712,500.0 | 0.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 635,154.0 | 818,089.3 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 1,514,793.2 | 1,832,095.0 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 1,243,357.0 | 1,513,773.5 |
| 1181 | Газрын төлбөр | 265,732.6 | 314,609.4 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 5,703.7 | 3,712.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,240,495.6 | 1,501,284.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,240,495.6 | 1,497,384.6 |
| 121 | Хөрөнгийн орлого | 0.0 | 3,900.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,915,166.5 | 4,231,802.3 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 14,921,078.5 | 22,058,282.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 14,921,078.5 | 22,058,282.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 9,842,747.3 | 11,996,859.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,094,419.6 | 1,882,005.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 149,871.2 | 252,112.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 140,406.5 | 4,304,014.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 81,700.5 | 95,337.9 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 46,223.0 | 522,477.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 27,806.2 | 31,405.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,101,969.1 | 1,283,626.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,200,351.2 | 3,625,879.4 |
| 212 | ТАТААС | 1,638,201.2 | 3,128,000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,440,129.9 | 6,933,423.2 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 3,327,565.0 | 5,718,421.8 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 1,298,210.5 | 2,895,069.1 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,298,210.5 | 2,895,069.1 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,298,210.5 | 2,895,069.1 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -1,298,210.5 | -2,895,069.1 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -450,000.0 | -140,000.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 450,000.0 | 140,000.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 1,579,354.4 | 2,683,352.7 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,063,979.0 | 2,643,333.4 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,643,333.4 | 5,326,686.1 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 26,611,757.4 | 26,611,757.4 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,922.7 | 1,922.7 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 26,613,680.1 | 26,613,680.1 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 9,740,736.5 | 9,740,736.5 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 160,664.6 | 160,664.6 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 36,515,081.2 | 36,515,081.2 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 36,515,081.2 | 36,515,081.2 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 98,632.6 | 98,632.6 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 36,613,713.7 | 36,613,713.7 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 814,191.0 | 814,191.0 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 983.3 | 983.3 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 5,539,364.2 | 5,539,364.2 |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 42,968,252.2 | 42,968,252.2 |

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 15,427,234.5 | 14,564,476.9 | 862,757.6 | 94.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 11,924,238.7 | 11,648,665.1 | 275,573.6 | 97.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,753,738.7 | 8,478,622.5 | 275,116.2 | 96.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,816,596.2 | 1,768,022.5 | 48,573.7 | 97.3 |
| 210101 | Үндсэн цалин | 839,924.8 | 828,206.8 | 11,718.0 | 98.6 |
| 210102 | Нэмэгдэл | 870,681.4 | 812,023.0 | 58,658.4 | 93.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 81,990.0 | 62,363.0 | 19,627.0 | 76.1 |
| 210104 | Урамшуулал | 24,000.0 | 65,429.8 | (41,429.8) | 272.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 239,248.3 | 218,406.1 | 20,842.2 | 91.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 164,592.4 | 152,142.2 | 12,450.2 | 92.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,663.9 | 17,224.0 | 1,439.9 | 92.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,332.1 | 8,847.6 | 484.5 | 94.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,332.1 | 7,978.5 | 1,353.6 | 85.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,327.8 | 32,213.9 | 5,113.9 | 86.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,435,814.3 | 4,304,014.3 | 131,800.0 | 97.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 305,717.6 | 275,028.3 | 30,689.3 | 90.0 |
| 210302 | Түлш, халаалт | 3,777,078.9 | 3,712,416.5 | 64,662.4 | 98.3 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 353,017.8 | 316,569.5 | 36,448.3 | 89.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 81,380.0 | 72,125.9 | 9,254.1 | 88.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 20,900.0 | 20,487.7 | 412.3 | 98.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,350.0 | 26,054.8 | 7,295.2 | 78.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,380.0 | 9,270.5 | 1,109.5 | 89.3 |
| 210404 | Ном, хэвлэл | 500.0 | - | 500.0 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,250.0 | 16,312.9 | (62.9) | 100.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 591,007.8 | 570,532.5 | 20,475.3 | 96.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 34,000.0 | 33,892.0 | 108.0 | 99.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210602 | Тавилга | 18,890.0 | 17,732.9 | 1,157.1 | 93.9 |
| 210604 | Урсгал засвар | 538,117.8 | 518,907.6 | 19,210.2 | 96.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 43,750.0 | 31,405.2 | 12,344.8 | 71.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,100.0 | 20,243.6 | 4,856.4 | 80.7 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 18,650.0 | 11,161.6 | 7,488.4 | 59.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,188,457.1 | 1,170,998.4 | 17,458.7 | 98.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,182,164.3 | 1,165,234.6 | 16,929.7 | 98.6 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,282.0 | 1,041.4 | 240.6 | 81.2 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 378.0 | 221.5 | 156.5 | 58.6 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 153.0 | 77.0 | 76.0 | 50.3 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,479.8 | 4,424.0 | 55.8 | 98.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 357,485.0 | 343,117.5 | 14,367.5 | 96.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 354,485.0 | 340,563.5 | 13,921.5 | 96.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000.0 | 2,554.0 | 446.0 | 85.1 |
| 212 | ТАТААС | 3,128,000.0 | 3,128,000.0 | - | 100.0 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 3,128,000.0 | 3,128,000.0 | - | 100.0 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 3,128,000.0 | 3,128,000.0 | - | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,500.0 | 42,042.6 | 457.4 | 98.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 42,500.0 | 42,042.6 | 457.4 | 98.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 42,500.0 | 42,042.6 | 457.4 | 98.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,088,345.2 | 2,775,811.8 | 312,533.4 | 89.9 |
| 223001 | Бусад хөрөнгө | 3,088,345.2 | 2,775,811.8 | 312,533.4 | 89.9 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 414,650.6 | 140,000.0 | 274,650.6 | 33.8 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 414,650.6 | 140,000.0 | 274,650.6 | 33.8 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 15,427,234.5 | 14,490,113.6 | 937,120.9 | 93.9 |
| 31 | Улсын төсвөөс санхүүжих | 935,854.4 | | 935,854.4 | |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 935,854.4 | | 935,854.4 | |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 11,825,731.4 | 14,265,087.2 | (2,439,355.8) | 120.6 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 11,825,731.4 | 13,329,232.8 | (1,503,501.4) | 112.7 |
| 320001 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | 935,854.4 | -935,854.4 | |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,665,648.7 | 225,026.4 | 2,440,622.3 | 8.4 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 220,000.0 | 196,593.2 | 23,406.8 | 89.4 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 28,433.2 | (28,433.2) | |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 2,445,648.7 | - | 2,445,648.7 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 603,147.7 | (603,147.7) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 528,784.5 | (528,784.5) | |

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 250,017.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 250,017.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 144,568.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,771.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,348.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,423.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 127,903.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 127,903.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,893.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,893.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 105,449.6 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 64,089.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 64,089.9 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 41,359.7 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 536.0 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 40,823.7 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 205,997.4 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 205,997.4 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 7,312.5 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 153,744.7 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 41,940.2 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 44,020.3 |

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 5 тусгай сан, 6 ОНӨААТҮГ-ийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 13 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа ЗДТГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 245.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 245.8 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 3.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 77.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитаар 8.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 67.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчлийн дүн тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

**Зөвлөмж**

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

   Илрүүлэлт:

   Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь давуулан биелүүлсэн хэдий ч ААНОАТ төлөвлөгөөг 156.4 сая төгрөгөөр, Агаарын бохирдол /авто/ орлогыг 45.4 сая төгрөгөөр, Агаарын бохирдол /нүүрс/ орлогыг 0.5 сая төгрөгөөр нийт 202.4 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.”хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Өгсөн зөвлөмж:

   Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах

2. **Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар**

   Илрүүлэлт:

   Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн 3 иргэнтэй холбоотой 43.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

   Өгсөн зөвлөмж:

   Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

3. **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар**

   Илрүүлэлт:

   Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 77.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитаар 8.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 67.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмжийг өгсөн байна.

   Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөрөн сумын ТТЗ | 1 | 3.1 | | | 1 | 3.1 | 1 | 3.1 | | |
| **Дүн** | **1** | **3.1** | | | **1** | **3.1** | **1** | **3.1** | | |
| Харьяа байгууллагуудын алдаа | | | | | | | | | | |
| Мөрөн сумын ЗДТГ | 2 | 19.3 | | | 2 | 19.3 | 2 | 19 | | |
| **Дүн** | 2 | 19.3 | | | 2 | 19.3 | 2 | 19.3 | | |
| **Нийт дүн** | **3** | **22.4** | | | **3** | **22.4** | **3** | **22.4** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Мөрөн ТТЗ | 3 | 245.8 | | | | | 3 | 245.8 | | | | |
| **Дүн** | **3** | **245.8** | | | | | **3** | **245.8** | | | | |
| Харьяа байгууллагуудын зөрчил | | | | | | | | | | | | |
| Мөрөн сумын ЗДТГ | 5 | 43.5 | 1 | 6.0 | 1 | 37.4 | 2 | | | | | |
| Мөрөн сумын ИТХ | 2 | 31.9 | 1 | 2.0 | 1 | 29.9 | | | | | | |
| Энэрэл ӨЭМТ | 1 | 0.3 | 1 | 0.3 | | | | | | | | |
| Энх-Үйлс ӨЭМТ | 1 | 0.8 | 1 | 0.8 | | | | | | | | |
| Гурван гал ӨЭМТ | 1 | 0.4 | 1 | 0.4 | | | | | | | | |
| Далайн элбэрэлт ӨЭМТ | 1 | 0.2 | 1 | 0.2 | | | | | | | | |
| **Дүн** | **11** | **77.1** | **6** | **9.7** | **2** | **67.3** | **2** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Нийт дүн** | **14** | **322.9** | **6** | **9.7** | **2** | **67.3** | **5** | **245.8** | **0** | **0** | **0** | **0** |